



МОНГОЛ УЛС
МОНГОЛБАНК

Бага тойруу 3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-11) 31 03 92, Факс: (976-11) 31 14 71,
Цахим хуудас: www.mongolbank.mn

2024.12.31 № А-1/992
танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА Р.СЭДДОРЖ ТАНАА

Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасны дагуу Эрдэнэсийн сангийн 2024 оны төсвийн гүйцэтгэл, 2025 оны төсвийн төслийн танилцуулга, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг өргөн мэдүүлж байна.

Эрдэнэсийн сангийн 2024 оны үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын гүйцэтгэл, 2025 оны үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын төсвийн төслийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлж өгөхийг Танаас хүсье.

Хавсралт ... хуудастай.

Хүндэтгэсэн

ЕРӨНХИЙЛӨГЧ



Б.ЛХАГВАСҮРЭН

1524032559

2024 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн
А-1/992 албан тоотын хавсралт

ЭРДЭНЭСИЙН САНГИЙН ҮНДСЭН БОЛОН ГҮЙЛГЭЭ САНГИЙН ОРЛОГО,
ЗАРЛАГЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Нийтлэг үндэслэл

Энэхүү тайланг боловсруулахдаа Эрдэнэсийн сангийн тухай хууль, Улсын Их Хурлын 2024 оны 04 дугаар сарын 19-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2024 оны төсөв”, Эрдэнэсийн сангийн үйл ажиллагааны журам, Дурсгалын зоос үйлдвэрлүүлэх, хадгалах, хамгаалах, зарцуулах журам, Үнэт металлын үйл ажиллагааны журам, Эрдэнэсийн сангийн мэргэжлийн зөвлөлийн хурлын шийдвэр, Эрдэнэсийн сангийн орлого, зарлагын тайланг үндэслэв.

Хоёр.Эрдэнэсийн сангийн төсвийн гүйцэтгэл

“Эрдэнэсийн сангийн тухай хууль”-ийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь хэсэгт Улсын Их Хурал нь Эрдэнэсийн сангийн жилийн орлого, зарлагын хэмжээ болон гүйцэтгэлийн тайланг батлах бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр тусгасан. Улсын Их Хурлын 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 29 дүгээр тогтоолоор “Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2024 оны төсөв” батлагдсан бөгөөд 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар дараах гүйцэтгэлтэй байна /Хүснэгт 1/.

Хүснэгт 1. Эрдэнэсийн сангийн 2024 оны төсвийн хүлээгдэж байгаа гүйцэтгэл /сая төгрөгөөр/

Дугаар	Бүлэг	Хэмжих нэгж	2024 оны төсөв	Гүйцэтгэл
Нэг . Үндсэн сан				
1.Орлого				
1.1	Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлс, байгалийн төрц алт худалдан авах, урлагийн бүтээл захиалан хийлгэх, археологи, түүхийн судалгааны байгууллагатай хамтран ажиллах	сая төгрөг	2,000.0	-
1.2	Чингис хаан баримлыг тээвэрлэх, угсралт, гэрэлтүүлэг, бусад ажлын зардал	сая төгрөг	1,500.0	747,4
1.3	Монголбанкны зөвшөөрлөөр цутгуулсан франчайз болон дурсгалын зоосны дээж	ширхэг	100	116
1.4	2018 оны 5 000 төгрөгийн загвар	ширхэг	2	2
1.5	1938 оны 2 төгрөг 50 мөнгөний вексел	ширхэг	1	1
1.6	Монголын худалдаа аж үйлдвэрийн банкны мөнгөний чек	ширхэг	1	1
1.7	20 000 төгрөгийн мөнгөн тэмдэгтийн хэв	ширхэг	1	1
1.8	Чингис хаан баримал	цогц	1	цогц
Хоёр . Гүйлгээ сан				
1.Орлого				
1.1	2024 онд үйлдвэрлэх дурсгалын зоос, бусад	ширхэг	гүйцэтгэлээр	17,283
2.Зарлага				

2.1	Дурсгалын зоос, алт мөнгөн гулдмай, үрлэн мөнгө		ширхэг	24 550	5,664
	2.1.1	Худалдах зориулалтаар	ширхэг	24 350	5,534
	2.1.2	Гадаад, дотоодын зочид, төлөөлөгчдөд дурсгалын зориулалтаар	ширхэг	200	130
Гурав . Бусад					
1.Үзэсгэлэн зохион байгуулах зардал					
1.1	Чингис хаан баримлыг үзэсгэлэнд дэглэх танхимын тохижуулалт, засварын зардал		сая төгрөг	2,900.0	2,300

I. Эрдэнэсийн сангийн 2024 оны үндсэн сангийн орлогын гүйцэтгэл

1.1 2024 онд сан хөмрөгийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2 тэрбум төгрөгийг Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлс, байгалийн төрц алт худалдан авах, урлагийн бүтээл захиалан хийлгэх, археологи, түүхийн судалгааны байгууллагатай хамтран ажиллахад зарцуулахаар төсөвлөсөн.

Эрдэнэсийн санд 2024 онд 7 иргэнээс эд зүйл худалдах тухай өргөдөл ирүүлсэн бөгөөд 2024 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн Эрдэнэсийн сангийн мэргэжлийн зөвлөлийн хурлаар эдгээр эд зүйлс нь Монголбанкны Эрдэнэсийн сангийн сан хөмрөгийг баяжуулахад тавигдах шаардлага хангахгүй тул худалдан авах боломжгүй гэж шийдвэрлэсэн бөгөөд төсвийн гүйцэтгэл 0 (тэг) төгрөг байна.

1.2 2024 онд Эрдэнэсийн сангийн Үндсэн санд орлогоор бүртгэх Чингис хааны алтадсан хүрэл баримлын холбогдох зардлын төсөв 1.5 тэрбум төгрөгөөр батлагдсан бөгөөд Чингис хаан музейн 9 давхрын хүндэтгэлийн өргөөнд дэглэн байршуулах Их эзэн Чингис хааны хүрэл баримлын ажлын гүйцэтгэл 747,4 сая төгрөг байна.

1. Чингис хааны баримлын жижгэрүүлсэн (1/10) хувилбар 2 ширхгийг үйлдвэрлүүлэхээр Итали улсын АртУ хүрэл баримлын үйлдвэртэй 0524/289 тоот “Ажил гүйцэтгэх гэрээ”-г байгуулсан.

2. Монголбанк, Бринкс Монгол ХХК хооронд байгуулсан 0523/261 дугаар гэрээнд нэмэлт төлбөр.

“Чингис хаан” алтадсан хүрэл барималыг бүтээлгэх ажил нь 2022 оноос эхлэн Улсын Их Хурлын тогтоолоор 2022, 2023, 2024 онуудад батлагдсан нийт төсөв 13.5 тэрбум төгрөг бөгөөд 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар гүйцэтгэл 13.0 тэрбум төгрөг байна.

1.3 2024 онд худалдаанд гарсан олон улсад худалдаалж байгаа Монголбанкны дурсгалын зоосны дээж болон франчайз зоос 100 ширхгийг орлогод авахаар төлөвлөсөн бөгөөд 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар 116 ширхэг дурсгалын зоосны дээжийг хүлээн авч, үндсэн сангийн байнгын бус хэсэгт орлогоор бүртгэв /Хүснэгт 2/.

Хүснэгт 2. 2024 онд Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн байнгын бус хэсэгт бүртгэгдсэн дээж зоосны жагсаалт.

№	Зоосны сэдэв	Металл /сорьц	Жин /грамм/	Худалдаанд гарсан он	Тоо /ширхэг/
Монголбанкны санаачилгаар:					
1	Монголбанк 100 жил /5гр/	мөнгө	5	2024	5
2	Хубилай хааны зарлиг /5 гр/	мөнгө	5	2024	5
3	Хубилай хааны зарлиг /1 унц/	мөнгө	31.1	2024	5
4	Хос луу /2 унц/	мөнгө	62.2	2024	5
5	Монголбанк 100 жил /2 унц/	мөнгө	62.2	2024	5

6	Монголбанк 100 жил /5 унц/	мөнгө	155.5	2024	5
7	Могой жил /Монгол/	мөнгө	31.1	2025	5
8	Сансарын хамтарсан нислэг 30 жил	мөнгө	1,000	2011	5
9	Чингис хаан /1 кг, алтадсан/	мөнгө	1,000	2024	5
Байгууллагын хүсэлтээр:					
1	Монгол-Швейцар 60 жил	мөнгө	5	2024	5
2	Үргэлж өөдөө	мөнгө	31.1	2024	5
3	Намжилын Норовбанзад	мөнгө	62.2	2024	5
4	Хубилай хааны усан флот	зэс	50	2024	5
5	Д.Жаргалсайхан	мөнгө	31.1	2024	5
Франчайз зоос					
1	Фаберже өндөг "Imperial Coronation Egg"	мөнгө	62.2	2024	5
2	Ирвэс /1/10 унц/	алт	3.1	2024	5
3	Ирвэс /3 унц/	мөнгө	93.3	2024	5
4	Ирвэс /2 унц/	мөнгө	62.2	2024	5
5	Ирвэс /1 унц/	алт	31.1	2024	5
Худалдаж авсан зоос					
1	Сансрын нисгэгч	мөнгө	1,000	2024	2
2	Лихтейнштейн швейцар франк 100 жил /1 унц/	мөнгө	31.1	2024	5
3	Эргэдэг зоос	мөнгө	31.1	2024	5
4	Лихтейнштейн швейцар франк 100 жил /1кг/	мөнгө	1,000	2024	2
5	Тифани Арт Метрополис-Сүүл Гёнбүхгүн ордон	мөнгө	155.5	2024	1
6	Ковбой Малгай	мөнгө	31.1	2024	5
7	Санторини /5 унц/	мөнгө	155.5	2024	1
Нийт					116

2024 оны 4-р улиралд Монголбанкны санаачилгаар болон байгууллагын хүсэлтээр захиалан үйлдвэрлүүлж буй “Чингис хаан” 1 кг-ын алтан дурсгалын зоос 10 ширхэг, “Хөрөнгийн зах зээлийн зохицуулагч байгууллага 30 жил” дурсгалын зоос 300 ширхгийг хүлээн авахаар төлөвлөж байна.

1.4 – 1.7 Эрдэнэсийн сангийн 2024 оны төсвийн 1.4-1.7-д тусгасан 2018 оны 5,000 төгрөгийн загвар 2 ширхэг, 1938 оны 2 төгрөг 50 мөнгөний вексель 1 ширхэг, Монголын худалдаа аж үйлдвэрийн банкны мөнгөний чек 1 ширхэг, 20,000 төгрөгийн мөнгөн тэмдэгтийн хэв 1 ширхгийг үндсэн сангийн байнгын бус хэсэгт орлогоор бүртгэсэн.

1.8 Чингис хаан баримал:

2024 онд “Чингис хаан” хүрэл баримал 1 ширхэг, “Чингис хаан” баримал жижиг 1 ширхгийг хүлээн авч, 2 ширхэгийг захиалан үйлдвэрлүүлэв.

II. Эрдэнэсийн сангийн 2024 оны гүйлгээ сангийн орлого, зарлагын гүйцэтгэл.

1. Орлого

1.1 2024 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн байдлаар Монголбанкны санаачилгаар болон франчайзаар үйлдвэрлэсэн дурсгалын зоос, үрлэн мөнгө 17,029 ширхэг, зоосны хайрцаг 200 ширхгийг, зоосны хэв 54 ширхгийг Эрдэнэсийн сангийн гүйлгээ санд орлогоор бүртгэн авсан.

2. Зарлага

2.1 2024 оны дурсгалын зоос:

Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дах заалтад “Үнэт болон бусад металлаар хийсэн дурсгалын зоос гаргах” гэж заасны дагуу 2024 онд Монголбанк 5 төрлийн дурсгалын зоос, байгууллагын захиалгаар 5 төрлийн дурсгалын зоос үйлдвэрлүүлсэн байна. /Хүснэгт 3/.

Хүснэгт 3. Монголбанк, байгууллагын хүсэлт санаачлагаар үйлдвэрлүүлсэн дурсгалын зоос.

№	Дурсгалын зоосны нэр	Тайлбар
1.	“Монголбанк 100 жил”	Монголбанкны 100 жилийн ойг тохиолдуулан 5гр, 2 унц, 5 унцын мөнгөн зоосыг үйлдвэрлүүлсэн.
2.	“Хос луу”	2019 оны дэлхийн шилдэг 10 археологийн олдворын нэг, ховор үнэт үзмэрт орсон Хүннүгийн үеийн олдвор болох хос лууг дүрсэлсэн. “Хос луу” дурсгалын зоосыг 2 унцын мөнгөөр үйлдвэрлүүлэв.
3.	“Хубилай хааны зарлиг”	Хубилай хаан 1260 онд хаан ширээнд заларсны дараа Монголын Их Юань улсад цаасан мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд оруулах тухай зарлиг буулгаж буй үйл ажиллагааг дүрсэлсэн уран зургаар ялтсан мөнгөн дэвсгэртийг 5гр болон 1 унц гэсэн төрлөөр үйлдвэрлүүлэв.
4.	“Могой жил”	2020 оноос эхлэн гаргасан 12 жилийн цуврал дурсгалын “Могой жил” зоосны үргэлжлэл үйлдвэрлүүлэв.
5.	“Чингис Хаан” 1 кг	“Чингис Хаан” хүрэл баримлын загвараар 1 кг-ын алтадсан мөнгөн дурсгалын зоосыг үйлдвэрлүүлэв.
6.	“Монгол-Швейцар” 60 жил	Швейцарын хөгжлийн агентлагтай хамтран Монгол-Швейцар улсын хамтын ажиллагааны ойг тохиолдуулан дурсгалын ялтсан мөнгөн дэвсгэртийг үйлдвэрлүүлэв.
7.	“Хубилай хааны усан флот”	Соёлын өвийн үндэсний төвтэй хамтран Япон улсын Мацүра хотын Такашима арлын далайн гүнээс илэрсэн Хубилай хааны Усан флотын цэргийн армийн хөлөг онгоцны дурсгал, тус түүхэн үйл явдлын 750 жилийн ойг тохиолдуулан “Хубилай хааны усан флот” дурсгалын зоосыг үйлдвэрлүүлэв.
8.	“Үргэлж өөдөө”	“АНУ ХК”- тай хамтран 2024 онд хүнсний ууган үйлдвэр “АНУ ХК”-ийн 100 жилийн ойг тохиолдуулан “Үргэлж Өөдөө” 1 унцын дурсгалын мөнгөн зоосыг үйлдвэрлүүлэв.
9.	“Норовбанзад”	“Норовбанзад сан” ТББ-аас Ардын жүжигчин, Төрийн соёрхолт, Хөдөлмөрийн баатар, Зууны манлай уртын дуучин Н.Норовбанзадын дүр бүхий дурсгалын зоос үйлдвэрлүүлэх хүсэлт ирүүлсний дагуу “Н.Норовбанзад” 2 унцын мөнгөн дурсгалын зоосыг үйлдвэрлүүлэв.
10.	“Д.Жаргалсайхан”	Монголын Дуулаачдын холбооноос ирүүлсэн хүсэлтийн дагуу Чингис хаан хамтлагийн дуучин Соёлын гавьяат зүтгэлтэн “Д.Жаргалсайхан” урлагт зүтгэсний 45 жилийн ойг тохиолдуулан дурсгалын зоосыг үйлдвэрлүүлэв.

2.1.1 “Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн үндсэн болон гүйлгээ сангийн орлого, зарлагын 2024 оны төсөв”-т гүйлгээ сангаас 24,550 ширхэг дурсгалын зоос болон алт, мөнгөн гулдмай, үрлэн мөнгө зарлагдахаар төсөвлөсөн.

Эрдэнэсийн сангийн гүйлгээ сангаас иргэд, аж ахуй нэгж байгууллагын хүсэлтийн дагуу дурсгалын зоос болон алт, мөнгөн гулдмай, үрлэн мөнгийг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар баталсан үнээр худалдаалдаг бөгөөд 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар оны эхнээс нийт 769.69 сая төгрөгийн өртөг бүхий 3983 ширхэг дурсгалын зоос,

3,769.09 сая төгрөгийн өртөг бүхий 1422 ширхэг алт мөнгөн гулдмай, үрлэн мөнгийг нийт 6 тэрбум төгрөгөөр худалдсан байна. /Хүснэгт 4/.

Хүснэгт 4. Дурсгалын зоос, алт, мөнгөн гулдмай, үрлэн мөнгөний зарлага. /2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар/

Он	Дурсгалын зоос		Алт, мөнгөн гулдмай, үрлэн мөнгө		Нийт өртөг /сая төг/
	тоо ш	өртөг /сая төг/	тоо /ш	өртөг /сая. төг/	
2018	360	31.33	-	-	31.33
2019	569	76.92	-	-	76.92
2020	606	114.74	190	438.93	553.67
2021	4,531	875.77	807	5,356.65	6,232.42
2022	2,973	566.79	234	795.05	1,361.85
2023	5,889	940.98	855	2317.64	3,258.92
2024.11.30	3'983	769.69	1'422	3'769.09	4'538.78

2.1.2 Энэ оны төсөвт зочин төлөөлөгчийн зардлаар бэлэг дурсгалд 200 ширхэг дурсгалын зоос зарцуулахаар тусгагдсанаас 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар оны эхнээс өссөн дүнгээр 130 ширхэг дурсгалын зоос зарцуулсан байна.

Франчайз зоос борлуулсны шимтгэл /роялти төлбөр/:

Монголбанк, Койн Инвест Траст компанитай 2024 оны 3 дугаар сарын 10-ны өдөр байгуулсан “Зоос үйлдвэрлэх ерөнхий гэрээ”-ний дагуу Койн Инвест Траст компани нь дурсгалын зоосны борлуулалтын шимтгэлийг улирал бүр Монголбанкны дансанд шилжүүлсэн бөгөөд 2024 оны III улирлын байдлаар нийт 27,330 ширхэг дурсгалын зоос борлуулж 150.8 сая төгрөгийн борлуулалтын шимтгэл төлсөн байна. /Хүснэгт 5/.

Хүснэгт 5. Дурсгалын франчайз зоос борлуулсны шимтгэлийн орлого 2024 оны III улирлын байдлаар, Монголбанкны дансанд орсон өдрийн валютын ханшаар тооцсон.

№	Улирал	Худалдан борлуулсан зоосны тоо ширхэг	Борлуулалтын шимтгэлийн төлбөр	
			Евро	Төгрөг
1	I	6'305	22'673.7	82'230'254.32
2	II	17'668	12'408.90	45'003'109.45
3	III	3'357	6'490.40	23'538'603.87
Нийт		27'330	41'573.00	150'771'967.64

III. Бусад зардалын гүйцэтгэл

3.1 Үзэсгэлэн зохион байгуулах зардал.

1. Үзэсгэлэн зохион байгуулах ажлын хүрээнд 2024 оны төсөвт 2,9 тэрбум төгрөг төсөвлөсөн. Монголбанк, Чингис хаан музейтэй байгуулсан 0523/244 тоот “Чингис хаан музейд үзэсгэлэн зохион байгуулахад хамтран ажиллах гэрээ”-ний дагуу Чингис хаан үндэсний музейн 9 давхрын хүндэтгэлийн танхимын засвар, дэглэлтийн ажилд 2,3 тэрбум төгрөгийн төлбөр төлөхөөс 1,6 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

2. Чингис хаан баримал бүтээсэн тухай сэтгүүлийг Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Чингис хаан музейтэй хамтран гаргахаар ажиллаж байна.

**Монгол Улсын Эрдэнэсийн сангийн үндсэн сангийн орлого,
гүйлгээ сангийн орлого, зарлагын 2025 оны төсөв**

Хүснэгт 1. Эрдэнэсийн сангийн 2025 оны төсвийн төсөл, хураангуй.

1.Үндсэн сангийн орлого:		Хэмжих нэгж	2024 Батлагдсан	2025 Төсөв
1.	Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлс, урлагийн бүтээл, байгалийн төрц алт худалдан авах, архелоги, түүхийн судалгааны байгууллагатай хамтран ажиллах	сая төгрөг	2,000	2,000
2.	Чингис хаан баримал үйлдвэрлүүлэх, угсрах, гэрэлтүүлгийн зардал.	сая.төгрөг	1,500	-
3.	Монголбанкны зөвшөөрлөөр цутгуулсан франчайз болон дурсгалын зоосны дээж.	ширхэг	100	гүйцэтгэлээр
4.	2018 оны 5000 төгрөгийн загвар	ширхэг	2	-
5.	1938 оны 2 төгрөг 50 мөнгөний вексел	ширхэг	1	-
6.	Монголын худалдаа аж үйлдвэрийн банкны мөнгөний чек	ширхэг	1	-
7.	20 000 төгрөгийн мөнгөн тэмдэгтийн хэв	ширхэг	1	-
8.	1945 оны зоосон мөнгө	ширхэг	-	2000
9.	Монголбанкны “Хүндэт банкир” жижиг тэмдэг	ширхэг	-	3
2.Гүйлгээ сангийн орлого:				
1	2025 онд үйлдвэрлүүлэх дурсгалын зоос, бусад	ширхэг	гүйцэтгэлээр	гүйцэтгэлээр
3.Гүйлгээ сангийн зарлага:				
	Дурсгалын зоос, алт, мөнгөн гулдмай, үрлэн мөнгө.			
1	2.1 Худалдах зориулалтаар	ширхэг	24,350	24,300
	2.2 Гадаад, дотоодын зочид, төлөөлөгчдөд дурсгалын зориулалтаар	ширхэг	200	200
4.Үзэсгэлэн зохион байгуулах танхимын дэглэлтийн зардал:				
1	Чингис хаан баримлыг үзэсгэлэнд дэглэх танхимын тохижуулалтын зардал	сая.төгрөг	2,900	-
2	Чингис хаан баримал болон Эрдэнэсийн сангийн сан хөмрөг дахь эд зүйлсийн сэлбэн тордолт, бусад ажил	сая.төгрөг	-	200

2025 оны дурсгалын зоосны үйл ажиллагаа:

2025 онд тохиох тэмдэглэлт ой, онцгой чухал үйл явдлын товчоог Хүснэгт 2-д харуулав.

Хүснэгт 2: Тэмдэглэлт ойн товчоо.

2025 онд тохиох тэмдэглэлт ойн сэдэв:		
Он, цаг хугцаа		Тайлбар
1925	100 жилийн ой	1925 онд анхны цаасан болон 1 төгрөгийн зоосон мөнгөн төгрөг гүйлгээнд гаргасан.
1925	100 жилийн ой	Монгол Улсад авто-тээврийн салбар үүсгэн байгуулагдсан.
1925	100 жилийн ой	Монгол Улсын Нисэх хүчин байгуулагдсан.

1950	75 жилийн ой	Зүүн Европын орнуудтай дипломат харилцаа тогтоов. (Болгар, Унгар, Польш, Румын)
1975	50 жилийн ой	Монгол Улс - Шинэ Зеланд, Монгол Улс - Кувейт, Монгол Улс - Мексикийн Нэгдсэн Улсын хооронд Дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ой.
1965	60 жилийн ой	Монгол-Франц дипломат харилцаа тогтоосны ой.
2006	30 жилийн ой	Жанрайсаг бурхан бүтээн залсаны ой.
1727	298 жилийн ой	Амарбаясгалан хийд
1635	390 жилийн ой	Анхдугаар Богд Өндөр Гэгээн Занабазарын мэлмий гийсний ой.

Монголбанкны Эрдэнэсийн сангаас 2025 онд дараах сэдвээр дурсгалын зоос үйлдвэрлүүлэхээр төлөвлөж байна. Үүнд:

1. “Морь жил” дурсгалын зоос:

Монголбанкны санаачилгаар 2020 онд 12 жилийн цуврал дурсгалын зоосыг үйлдвэрлэж эхэлсэн бөгөөд 2020 онд “Хулгана жил”, 2021 онд “Үхэр жил”, 2022 онд “Бар жил”, 2023 онд “Туулай жил”, “Луу жил”, “Могой жил”-ийн дурсгалын мөнгөн зоосыг Койн инвест Траст компанид үйлдвэрлүүлж хүлээн авч, худалдаалж байна. Уг цувралын үргэлжлэлээр 2026 онд тохиох “Морь жил” дурсгалын зоосны загвараар 2025 онд захиалан үйлдвэрлүүлнэ.

2. “12 жил” дурсгалын зоос

12 жилийн сэдэвтэй дурсгалын ялтсан мөнгөн дэвсгэртийг 1 сэт болгон гаргахаар судлан ажиллаж байна.

3. “1925 он” дурсгалын зоос

1925 онд цаасан болон зоосон мөнгөн төгрөг гүйлгээнд нэвтэрсэний 100 жилийн ойг угтан дурсгалын зоос, ялтсан дэвсгэртийг үйлдвэрлүүлэх талаар судлан ажиллаж байна.

4. “Монгол-Франц” 60 жилийн ой

Монгол улс, Франц дипломат харилцаа тогтоосны 60 жилийн ойг угтан дурсгалын зоос гаргахаар судлан ажиллаж байна.

5. “Занабазар 390 жил” дурсгалын зоос

2025 онд тохиох Анхдугаар Богд Өндөр Гэгээн Занабазарын мэлмий гийсний 390 жилийн ойг тохиолдуулан дурсгалын зоос үйлдвэрлүүлэх талаар судлан ажиллаж байна.

6. Бусад

2025 онд тохиох бусад тэмдэглэлт ой, онцгой чухал үйл явдлын сэдвээр холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах.

МОНГОЛ УЛСЫН ЭРДЭНЭСИЙН САНГИЙН
ҮНДСЭН САНГИЙН ОРЛОГО, ГҮЙЛГЭЭ
САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГЫН 2025 ОНЫ ТӨСӨВ

№	Бүлэг	Хэмжих нэгж	2025 төсөв
1. Үндсэн сангийн орлого			
1	Түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлс, урлагийн бүтээл түүний засвар сэргээн засварлах, байгалийн төрц алт худалдан авах, архелог, түүхийн судалгааны байгууллагатай хамтран ажиллах	сая.төгрөг	2,000
2	Монголбанкны зөвшөөрлөөр цутгуулсан франчайз болон дурсгалын зоосны дээж	ширхэг	гүйцэтгэлээр
3	1945 оны зоосон мөнгө	ширхэг	2000
4	Монголбанкны “Хүндэт банкир” жижиг тэмдэг, хайрцаг	ширхэг	3
2. Гүйлгээ сангийн орлого:			
1	2025 онд үйлдвэрлэсэн дурсгалын зоос, бусад	ширхэг	гүйцэтгэлээр
3. Гүйлгээ сангийн зарлага:			
Дурсгалын зоос, алт мөнгөн гулдмай, үрлэн мөнгө:		ширхэг	24,500
1	1.1 Худалдах зориулалтаар	ширхэг	24,300
	1.2 Гадаад, дотоодын зочид, төлөөлөгчдөд дурсгалын зориулалтаар	ширхэг	200
4. Бусад			
1	Чингис хаан баримал болон Эрдэнэсийн сангийн сан хөмрөг дахь эд зүйлсийн сэлбэн тордолт, бусад ажил	сая.төгрөг	200